

Дундговь аймгийн Засаг даргын Зам тээврийн хөгжлийн яамны сайдтай 2023 онд хамтран ажиллах гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 12

Мандалговь хот

### **НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Зам тээврийн хөгжлийн яамны сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг сайжруулж, цаашид гарах үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

### **ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Зам тээврийн хөгжлийн яамны сайдтай байгуулсан аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

### **ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН**

Зам тээврийн хөгжлийн яамны сайдтай байгуулсан аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу хийхэд хамтран ажиллах гэрээгээр 20 үүргийг хүлээж, хэрэгжүүлэн ажилласнаар жилийн эцсийн байдлаар 92,3 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Нийт 20 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 14 арга хэмжээ 100 хувь, 2 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ 30 хувьтай байна.

### **ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:**

2023 оны замын сангийн хөрөнгөөр аймгийн төвийн Сайнцагаан сумын Номгон дэлгүүрийн урд замаас сургуулийн гудамж хүртэлх зам талбайн тохижилтын

ажлын гүйцэтгэгчээр Нөон гэгээ ХХК шалгарч 581.9 сая төгрөгийн гэрээ байгуулан хүлээн авав.

2023 онд Мандалговь-УБ чиглэлийн авто замын урсгал засварт Дундговь авто зам засварыг гүйцэтгэх 1050.0 сая, Улсын төсвөөс 193-198 дах км замд бүрэн засвар хийгдэх 3.7 тэрбум, Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замын урсгал засварт Дундговь авто зам засвар арчилгаа хийх 950.0 сая, Улсын төсвөөс 14-19 дах км замд бүрэн засвар хийгдэх 3.4 тэрбум, 19-23 дах км замд бүрэн засвар хийгдэх 2.8 тэрбум төгрөг тус тус батлагдаж ажлын гүйцэтгэж, улсын комисс хүлээж аваад байна.


“Такси үйлчилгээ” ерөнхий шаардлагын MNS5122:2013 стандартын дагуу такси үйлчилгээ эрхлэх гэрээ байгуулах аж ахуй нэгж байхгүй бөгөөд хувиараа такси үйлчилгээ эрхэлдэг 42 жолооч байгаа бөгөөд 5-6 удаагийн хяналт шалгалтыг хийж ажиллаа.

Дундговь аймгаар дамжин өнгөрч байгаа Улаанбаатар-Өм. Цогцэций, Улаанбаатар-Өм.Цагаанхад, Улаанбаатар-Өм. Даланзадгад чиглэлийн хот хоорондын зорчигч тээврийн автобусанд хяналт тавин зорчиж буй иргэдэд тасалбар олгон ажиллаж байна.



Дундговь аймгийн Авто тээврийн төвийн авто тээврийн хяналтын мэргэжилтнүүд нь Их газрын чuluу байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны алба хаагчдын хамт Сайнцагаан, Гурвансайхан, Өлзийт сумдын нутаг дэвсгэрт хяналт шалгалтын ажил үүрэг гүйцэтгэж зөвшөөрөлгүй зам маршрут зөрчихөөс гадна хяналт шалгалтад холбогдолтой баримт бичиг дутуу, замын хуудас, ачааны дагалдах бичиггүй зэрэг зөрчил дутагдууд ихээр илэрч байна. Зөвшөөрөлгүй зам маршрут зөрчсөн 14 тээврийн хэрэгслийн бичиг баримтыг хураан авч шийтгэлийн хуудас ирээгүй байсан тул эрх бүхий албан тушаалтанд шилжүүлж ажилласан.

2023 оны 04 сарын 01-ээс А0201 хатуу хучилттай зам дагуу Дундговь аймгийн цагдаагийн газрын алба хаагчидтай хамтран хяналт шалгалтаар тогтмол ажиллаж хялбаршуулсан журмаар 5 аж ахуй нэгж 19 иргэнд 10350000 төгрөгийн арга хэмжээ авч хяналт шалгалтад саад учруулж бичиг баримт шалгуулахгүй явсан 12 тээврийн хэрэгсэлд чагтлах арга хэмжээ авч 13 тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгуулж ажилласан.



### ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний зам тээврийн салбарын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 92,3 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт Тээврийн хяналтын улсын байцаагч байхгүй ч авто тээврийн салбарын гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн автотээврийн төвийн улсын байцаагч нар хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллаж байна. Цаашид мэргэжлийн хүний нөөцөө бүрдүүлэн ажиллах шаардлагатай гэж үзлээ.

2023 оны гэрээний үүргээс Дундговь аймаг дахь “Мандалговь” нисэх буудлын аэродром орчмын аюулгүй бүсийн газрыг зохих журмын дагуу улсын тусгай хэрэгцээнд авах шийдвэрийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх гэсэн арга хэмжээний хэрэгжилт удаашралтай байгаа нь бодлогын мэргэжилтэн байхгүйтэй холбоотой байна.

Сайдтай байгуулсан гэрээгээр хүлээсэн

- Авто зам, замын байгууламжийн барилгын ажилтай холбоотойгоор газар түр ашиглах, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, авто зам, гүүрний барилгын

- ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зэрэг орон нутгийн оролцоотойгоор шийдвэрлэгдэх асуудлыг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэж байх
- Орон нутгийн нислэгийг сэргээх, нөхөн олговортой нислэг гүйцэтгүүлэх, нөхөн олговрын санхүүжилтийг аймгийн 2023 оны төсөвт тусгах
  - Монгол Улсын Их хурлын 2022 оны 72 дугаар тогтоол болон Засгийн газрын 2022 оны 448 дугаар тогтоолд тус тус даалгасны дагуу холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аймгийн харьяа иргэнд орон нутгийн нислэгийн тийзийн үнийн хөнгөлөлтийг аймгийн 2023 оны төсвөөс санхүүжүүлэх зэрэг үүргүүдийн хүрээнд тодорхой ажил хийгдээгүй нь орон нутгаас шалтгаалаагүй гэж үзэн үнэлгээнээс хасаж тооцлоо.

#### ТАВ. ЗӨВЛӨМЖ

#### **Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст**

1. Гэрээнд тусгагдсан үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө суурь түвшин, хүрэх түвшнийг бодитой судалгаанд үндэслэн тодорхойлох
2. Тайланг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу хүрэх түвшинд хүрсэн эсэхийг тайлагнахаас гадна үр дүн, үр нөлөөний талаар тайлагнаж хэвших мөн нотлох баримтыг тайланд хавсаргаж байх
3. Дараа оны гэрээний төсөлд төсөв хөрөнгө нь тодорхой, үр дүн гарагуйц бодитой ажлуудыг тусгах саналыг яам руу уламжлах
4. Тээврийн хяналтын улсын байцаагчийн орон тоог яаралтай нөхөх арга хэмжээ авах


Баталгаажуулсан:

Аймгийн Засаг дарга  Д.Мөнхбат

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн

дарга



Д.Даариймаа

Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний

хэлтсийн ахлах мэргэжилтэн



Э.Одончимэг